

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа	2026 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2026 оны 6 дугаар сарын 31-ны өдөр	
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	“Мах импэкс” ХК, УБГД: 9010001046 ҮЦК: Утасны дугаар: (+976) 70172471	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл худалдаа	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	3 800 721	
Хагс жил, улирлын тайланг бэлтгэсэн мэрэгжилтэн. Хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Ерөнхий нябо С.Мөнхжаргал ТУЗ-ийн НБДарга Өлзийбаяр Хянасан: Гүйцэтгэх захирал Г.Будрагчаа	
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	<u>Тайланг хавсаргав</u>
	Орлогын тайлан	<u>Тайланг хавсаргав</u>
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	<u>Тайланг хавсаргав</u>
	Мөнгөн гүйлгээний тайлан	<u>Тайланг хавсаргав</u>
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	Компанийн борлуулалтын орлого зах зээлийн үнийн өсөлт түүхий эдийн нийлүүлэлтээс шалтгаалан буурсан нөхцөл байдал үүссэн боловч манай компанийн шинэ бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн шинэчлэлд ихээхэн хөрөнгө зарцуулсан.	
2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/ нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
	Тайлант хугацаанд компанийн борлуулалтын орлого нь зах зээлийн үнийн өсөлт, түүхий эдийн нийлүүлэлтийн тогтворгүй байдал зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр өмнөх тайлант үеэс буурсан үзүүлэлттэй гарлаа.	

	Хэдий тийм боловч компанийн урт хугацааны тогтвортой хөгжил, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн шинэ бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн шинэчлэлд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн. Энэхүү хөрөнгө оруулалт нь үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг сайжруулах, үйлдвэрлэлийн зардлыг бууруулах үндэс суурийг бүрдүүлж байна. Иймд дээрх бүтээн байгуулалт, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн үр өгөөж нь ойрын жилүүдэд бодитоор илэрч, компанийн борлуулалтын орлого, ашигт ажиллагаа болон зах зээлд эзлэх байр суурийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулна гэж үзэж байна.	
2.1	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	ROA=4.3% ROE=21.4% EPS=548.2 ROTA=1.17
2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Зээл даахуйц санхүүгийн нөөц чадвартай.
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Тус компани нь тайлант хугацаанд 36,7 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн бөгөөд үүнээс 15,3 тэрбум төгрөгийн экспортын борлуулалт хийгдсэн. Мөн өмнөх жилүүдийн адил нийслэлийн хүн амын хэрэгцээнд 926 тн нөөцийн мах бэлтгэн борлуулсан. Ирэх жилүүдэд компани экспортын борлуулалтанд түлхүү анхааран ажиллах төлөвлөгөөтэй байна.
2.4	Санхүүгийн байдлын тайлангийн бүртгэгдсэн ажил, гүйлгээний дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүү байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй болно.
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл	Тус компани нь 80 жилийн ойн хүрээнд үйлдвэр болон зоорийг шинэчлэхээр МИК-80 төслийг эхлүүлэн ажиллаж байна. Уг төслийн Хөрөнгө оруулалтанд зориулан ХХБ-наас 30,2 тэрбум төгрөгийн зээл авсан бөгөөд зээл төлөлт хуваарийн дагуу хийгдэж байна.
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/ <u>Байхгүй</u>	
4.	Цалин урамшууллын мэдээлэл <u>Тайлант хугацаанд ажилчдын цалин хөлсөнд өөрчлөлт ороогүй болно.</u>	

	2026 оны бүтэц орон тоогоор 143 байнгын ажлын байранд 120 ажилтан албан хаагчидтай ажиллаж байна. Компани нь захиргаа, санхүү, борлуулалт, МБҮ, машин танхим, сантехник, цахилгаан, засвар, автограж гэсэн цех нэгжүүдтэй.
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл
	“Мах импэкс” ХК нь 2026 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон төлөөлөн урдирдах зөвлөл нь ердийн 6 хараат бус 3 нийт 9 гишүүн ажилллаж байна.
6.	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл
	Эрсдэлгүй
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/
	Тус компанийн хувьцааны 5%-иас дээш багцыг эзэмшдэг хувьцаа эзэмшигчид: 1. Х.Баттулга-1473880-38,8% 2. Б.Оргилболд-428743-11,3% 3. Б.Оргилбат-313475-8,2% 4. Х.Баттуул-206358-5,4% 5. Баянгол зочид буудал ХК-474566-12,5% тус тус эзэмшиж байна.
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл
	Төсөлд зориулан хувьцаа гаргаагүй болно.
9.	Ногдол ашгийн мэдээлэл
	Нэгж хувьцаанд 100 төгрөгийн ногдол ашиг олгохоор ТУЗ-ийн тогтоол гарсан бөгөөд 2026 оны эхний хагас жилд онуудын хувьцааны ногдол ашгийг ҮЦТХТ-тэй гэрээ байгуулан тарааж байна.
10.	Үнэт цаас гаргагчаас тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл
	Тайлант хугацаанд нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажил 1. Үйлдвэрийн хэрэгцээнээс гарсан бохир усыг шинэчилсэн стандартад хийцүүлэх, шинээр бохир ус цэвэрлэх байгууламж барих ажлыг эхлүүлээд байна. 2. Өндөр насны тэтгэвэрт гарсан 100 гаруй ахмадуудыг сар шүнийн баярыг тохиолдуулан өөрийн байранд хүлээн авч хэвийн боов өгсөн бөгөөд зарим ахмад ажилчдад буцалтгүй тусламж олгосон.
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:	
Овог, нэр: Г.Бүдрагчаа Албан тушаал: Мах Импэкс ХК-ийн Гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/ тэмдэг) Овог, нэр: С.Мөнхжаргал	Овог, нэр: Албан тушаал: ХХК аудитийн компанийн гүйцэтгэх захирал Гарын үсэг: (Тамга/ тэмдэг)

МАХ ИМПЭКС ХК



Албан тушаал: Мах Импэкс ХК-ийн
Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: И.Өлзийбаяр

Албан тушаал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

Гарын үсэг: